



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/09-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Д.Чулуунцэцэг

Утас: 70363036 Цахим хаяг: chuluuntsetseg.d@audit.local

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.3 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн дансны тайлан	10
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	15
3.5.2 Авлага	15
3.5.3 Бараа материал.....	16
3.5.7 Орлогын данс	19
3.5.8 Зардлын данс	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	20
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	24
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	25
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
4.1 Залруулсан алдаа.....	27
4.4 Зөвлөмж	29
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА П. БАТБААТАР ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА 2022/09-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

СЭА-2022/09/-НА-СТА-ТТЗ

018020413


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	641,048.7	947,599.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	300,485.2	490,997.7
33	АВЛАГА	169,696.6	217,138.6
35	БАРАА МАТЕРИАЛ	170,867.0	239,463.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,150,471.3	6,495,663.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,150,471.3	6,495,663.8
39200	Биет хөрөнгө	6,002,622.6	6,349,715.9
39300	Биет бус хөрөнгө	147,848.7	145,947.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,791,520.0	7,443,263.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,570.0	62,442.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	42,570.0	62,442.6
41300	Өглөг	42,570.0	62,442.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,748,950.0	7,380,821.0
51	Засгийн газрын хувь оролцоо	6,748,950.0	7,380,821.0
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,899,045.4	1,899,045.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,338,733.8	1,970,604.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,511,170.8	3,511,170.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,791,520.0	7,443,263.6

2.2 Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,853,894.6	4,641,386.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	99,482.9	199,826.4
110	Орлогын албан татвар	65,232.6	66,966.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	65,232.6	66,966.8
113	Хөрөнгийн албан татвар	1,080.0	97,762.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	33,170.3	35,097.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,541,146.9	754,509.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,541,146.9	754,509.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,213,264.8	3,687,049.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,462,063.2	3,739,271.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,462,063.2	3,739,271.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,294,002.3	3,559,255.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,895,269.7	1,988,443.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	243,834.2	260,571.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	402,024.6	425,067.8
2104	Хангамж, бараа материалын зардал	80,166.6	80,079.0
2105	Нормативт зардал	197,286.5	260,317.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,628.0	35,318.2
2107	Томилолт, зочны зардал	3,899.8	5,009.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,624.9	54,150.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	427,268.2	450,297.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,168,060.8	180,016.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,391,831.4	902,114.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,578.2	270,243.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,327,253.2	631,871.0

2.3 Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,348,506.5	3,971,674.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	99,482.9	199,826.4
110	Орлогын албан татвар	65,232.6	66,966.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	65,232.6	66,966.8
113	Хөрөнгийн албан татвар	1,080.0	97,762.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	33,170.3	35,097.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,224.7	5,074.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	30,945.6	24,969.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,943.9	109,737.9
120	Нийтлэг татварын бус орлого	21,943.9	109,737.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,227,079.7	3,662,110.2
II	НИЙТ ЗАРЛАГА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,160,274.5	3,404,152.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,160,274.5	3,404,152.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,890,453.7	3,178,083.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,890,913.0	1,989,066.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	244,092.8	259,332.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	405,031.5	431,627.7
2104	Хангамж, бараа материалын зардал	80,030.4	79,754.0
2105	Нормативт зардал	170,898.2	239,089.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,588.5	23,127.0
2107	Томилолт, зочны зардал	3,899.8	5,009.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,086.2	55,594.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,913.4	95,482.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,269,820.7	226,069.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	188,232.0	567,521.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	114,190.0	302,009.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	114,190.0	302,009.1
2200	Дотоод эх үүсвэрээр	114,190.0	302,009.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-114,190.0	-302,009.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-75,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	75,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,042.0	190,512.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	226,443.1	300,485.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,485.2	490,997.7

2.4 Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,421,696.8	5,421,696.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,421,696.8	5,421,696.8
9	Тайлант үеийн үр дүн	1,327,253.2	1,327,253.2
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,748,950.0	6,748,950.0
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,748,950.0	6,748,950.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,748,950.0	6,748,950.0
19	Тайлант үеийн үр дүн	631,871.0	631,871.0
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,380,821.0	7,380,821.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Гүйцэтгэл хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,635,508.40	3,339,624.47	295,883.93	91.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,137,615.10	2,994,380.53	143,234.57	95.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,045,812.70	2,907,257.52	138,555.18	95.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,015,213.10	1,965,584.28	49,628.82	97.5
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	272,892.30	256,354.74	16,537.56	93.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	465,556.40	430,628.42	34,927.98	92.5
2104	Хангамж, бараа материалын зардал	63,764.90	63,508.30	256.60	99.6
2105	Нормативт зардал	96,704.00	80,305.95	16,398.05	83.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,550.10	47,003.40	546.70	98.9
2107	Томилолт, зочны зардал	5,498.70	3,992.70	1,506.00	72.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,315.50	30,590.28	3,725.22	89.1

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,317.70	29,289.45	15,028.25	66.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	91,802.40	87,123.01	4,679.39	94.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,802.40	87,123.01	4,679.39	94.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,327.90	32,833.61	4,494.29	88.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,834.40	50,834.40	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,640.10	3,455.00	185.10	94.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	400,551.10	270,243.94	130,307.16	67.5
220001	Барилга байгууламж	215,551.10	187,973.79	27,577.31	87.2
221001	Их засвар	180,000.00	82,270.16	97,729.85	45.7
223001	Бусад хөрөнгө	5,000.00	0.00	5,000.00	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	97,342.20	75,000.00	22,342.20	77.0
230001	Эргэж төлөгдөх зээл	97,342.20	75,000.00	22,342.20	77.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,635,508.40	3,391,290.27	275,079.83	91.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,939,878.30	1,939,878.30	-	100
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,939,878.30	1,939,878.30	-	100
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,396,211.80	1,317,590.66	78,621.14	94.4
320001	Орон нутгийн төсвөөс	1,157,849.80	1,079,228.66	78,621.14	93.2
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	238,362.00	238,362.00	0.00	100.0
33	ЭМД САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,202.20	27,928.63	10,273.57	73.1
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	38,202.20	27,928.63	10,273.57	73.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	261,216.10	75,030.98	186,185.12	28.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,500.00	75,030.98	-54,530.98	366.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	240,716.10	0.00	240,716.10	0.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,492,134.50	0.00	3,492,134.50	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	240,716.09	-240,716.09	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	209,854.40	-209,854.40	

2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн дансны тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,398.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,398.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,591.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,482.66
210101	Үндсэн цалин	17,224.78
210102	Нэмэгдэл	6,257.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,977.38
210201	Тэтгэврийн даатгал	2,436.57
210202	Тэтгэмжийн даатгал	135.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	108.16
210204	Ажилгүйдлийн даатгал	27.04
210205	Эрүүл мэндийн даатгал	270.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	999.30
210301	Гэрэл, цахилгаан	153.24
210302	Түлш, халаалт	827.19
210303	Цэвэр, бохир ус	18.88
2104	Хангамж, бараа материалын зардал	16,464.02
210401	Бичиг хэрэг	662.00
210402	Тээвэр, шатахуун	11,907.72
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	391.00
210404	Ном, хэвлэл	3,012.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	491.00
2105	Нормативт зардал	158,783.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	158,478.92
210502	Хоол, хүнс	304.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,070.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,270.00
210602	Тавилга	800.00
210604	Урсгал засвар	1,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,016.43
210701	Гадаад албан томилолт	0.00
210702	Дотоод албан томилолт	1,016.43
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,604.75
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,604.75
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,193.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,193.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	80,807.18
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,407.18
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,838.29

213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,568.90
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	383,398.44
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	383,398.44
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	36,306.05
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,637.43
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	157,757.32
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	85,697.64
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Цаашид Орхонтуул сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж байх, тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтлөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 5-ны өдрийн 1/99 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхонтуул сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүлээж суух биш –Хүрч үйлчилье” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Засгийн газар болон аймаг сумын ИТХ-ын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үндсэн нөхцөлийг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг ард иргэддээ тэгш шударга, хөнгөн шуурхай хүргэх,
- Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны

журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,

- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Орхонтуул сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчаас дотоод аудит хийгдээгүй байна.

ТТЗ-ийн удирдлагын зүгээс тайлант онд хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхонтуул сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох **3,739,271.2** мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **56,089.0** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 42,066.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 300,485.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 490,997.7 мянган төгрөг болж, 190,512.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	300,485.2	490,997.7	190,512.5	163.4
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	300,485.2	490,997.7	190,512.5	163.4

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд ерөнхий орлогын 252,369.0 мянган төгрөг, СХС-ын 76,908.1 мянган төгрөг, ОНХС-ийн 130,307.1 мянган төгрөг, ЭМТ-үүдийн харилцах дансны 2,639.2 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны 28,774.3 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 169,696.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 217,138.5 мянган төгрөг болж, 47,422.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,402.2	1,584.9	182.7
Татаас, санхүүжилтийн авлага	27,576.3	70,380.4	42,804.1
Зээлийн хүүгийн авлага	8,032.9	6,578.1	(1,454.8)
Хувь хүмүүсээс авах авлага	4,890.8	4,591.3	(299.5)
Зээлийн авлага	127,794.3	134,003.8	6,209.5
Дүн	169,696.5	217,138.5	47,422.0

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлага 47,442.0 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн авлага 42,804.1 мянган төгрөгөөр, ажиллагчидтай холбогдсон авлага 182.7 мянган төгрөгөөр, СХС-аас олгосон зээлийн авлага 6209.5 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай /нийт/ 35,331.5 мянган төгрөгийн СХС-ийн зээл, зээлийн хүүгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар шүүхэд 4, ШШГГ-т 6 зээлдэгчийн материалыг хүргүүлж, мэдэгдэх хуудас өгч ажилласан байна.

Тайлант онд монгол банкны хугацаа хэтэрсэн зээлийн мэдээллийн санд мэдээллийг бүрэн шивж оруулснаар зээлийн эргэн төлөлт сайжирч, СХС-ийн зээлийн эргэлтийн эх үүсвэр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас дараах байгууллагууд авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Үүнд:

- 1 дүгээр сургууль 722.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага,
- 2 дугаар сургууль 186.7 мянган төгрөгийн түрээсийн номын авлага,
- Цэцэрлэг 268.2 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 170,866.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 239,463.5 мянган төгрөг болж, 68,596.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

				/мянган төгрөг/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
35130	Эм боох материал	58,793.0	71,555.6	12,762.6
35400	Хангамжийн материал	112,073.9	167,907.9	55,834.0
35410	Бичиг хэргийн материал	5,980.2	7,696.0	1,715.7
35420	Аж ахуйн материал	79,274.3	128,042.9	48,768.7
35430	Сэлбэг хэрэгсэл	3,084.4	1,620.0	(1,464.4)
35460	Хүнсний материал	346.7	6,544.6	6,197.8
35470	Бусад хангамжийн материал	23,388.2	24,004.4	616.2
	Дүн	170,866.9	239,463.5	68,596.5

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 750,540.1 мянган төгрөгийн материалыг төсвийн хөрөнгөөр, 4,265.6 мянган төгрөгийн материалыг хандиваар, 54,107.2 мянган төгрөгийн материалыг үнэ төлбөргүй орлогоор хүлээн авч, 483,592.6 мянган төгрөгийн материал зарцуулж, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 256,723.7 мянган төгрөгийн бараа материалыг ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 68,596.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эм боох материал, аж ахуйн материал, хүнсний материалын үлдэгдлүүд өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 1,244.1 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 32,423.7 мянган төгрөгийн,
- Тосгоны захирагчийн алба нь 8,250.3 мянган төгрөгийн,
- Орхонтуул сумын Соёлын төв нь 418.3 мянган төгрөгийн,
- Рашаант тосгоны Соёлын төв нь 324.5 мянган төгрөгийн,
- 1 дүгээр сургууль 26,808.2 мянган төгрөг
- 2 дугаар сургууль 23,824.7 мянган төгрөг
- Орхонтуул сумын ЭМТ нь 31,490.4 мянган төгрөгийн,
- Рашаант тосгоны ЭМТ нь 30,624.5 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг 27,477.2 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **7,372,314.0** мянган төгрөг байсан бол оны эцсийн үлдэгдэл **8,078,680.9** мянган төгрөг болж, **706,366.9** мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	6,032,336.1	6,170,405.4	138,069.3
Авто-тээврийн хэрэгсэл	284,298.5	296,778.5	12,480.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	403,300.5	479,942.5	76,642.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	311,619.3	345,142.8	33,523.5
Зам, гүүрийн байгууламж	47,969.9	379,461.6	331,491.7
Бусад үндсэн хөрөнгө	128,309.8	240,290.8	111,981.0
Ном	15,704.4	17,883.8	2,179.4
Програм хангамж	9,675.0	9,675.0	-
Бусад биет бус хөрөнгө/Газар/	139,100.4	139,100.4	-
ДҮН	7,372,314.0	8,078,680.9	706,366.9

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд /анхны өртгөөр/ төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн **31,765.2** мянган төгрөгийн тоног төхөөрөмж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 189,085.5 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа, ЭМТ-ийн түргэн тусламжийн 35,000.0 мянган төгрөгийн автомашин, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 100,000.0 мянган төгрөгийн жишиг гудамжны зам гэрэлтүүлэг, шинээр ашиглалтад орсон соёлын төвийн 95,472.3 мянган төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, сумын ОНХС-аар бэлтгэсэн ёслол хүндэтгэлийн өргөө,

хогийн цэгийн хашаа, явган хүний гүүр, малын угаалгын ванн зэрэг 270,243.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, аймгийн ИТХ-ын 2020 оны 59 дүгээр тогтоолоор Рашаант тосгоны ЭМТ-ийн **15,200.0** мянган төгрөгийн автомашиныг актлах шийдвэр гаргасны дагуу данс бүртгэлээс хасаж бүртгэсэн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 42,130.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 62,002.9 мянган төгрөг болж, 19,872.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Өр төлбөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бусад өглөг	41,673.3	61,977.9	20,304.6
Байгууллагад төлөх өглөг	457.0	25.0	-432.0
Дүн	42,130.3	62,002.9	19,872.6

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгалийн баялгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн данснаас иргэн аж ахуйн нэгжид олгох 28,774.3 мянган төгрөг, оны эцэст төсөвт төвлөрүүлсэн 16,568.8 мянган төгрөг, ажиллагсадтай холбогдсон тооцооны 25.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 16,634.8 мянган төгрөгийн зэрэг нийт 62,002.9 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүй өглөг, авлага ба төлбөрийн тооцоог урьдчилан хянаагүйн улмаас дараах өр төлбөр үүсгэсэн байна. Үүнд:

- 1 дүгээр сургууль нь 75.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр,
- 2 дугаар сургууль нь 428.0 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр,
- Цэцэрлэг нь 609.7 мянган төгрөгийн цалингийн суутгалыг шилжүүлэлгүй өр төлбөр үүсгэсэн байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,748,950.05 мянган төгрөг байсан бол 7,380,821.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 631,870.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	1,899,045.45	1,899,045.45	-
Хуримтлагдсан үр дүн	1,338,733.78	1,970,604.75	631,870.96
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,511,170.82	3,511,170.82	-
Дүн	6,748,950.05	7,380,821.01	631,870.96

Эх сурвалж: Орхонтуул сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон сумын ЗДТГ-ын 465.0 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн 74,566.0 мянган төгрөг зэрэг нийт 75,031.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **19,016.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ:

- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ОНХС-гаас техник хяналтын зардалд 973.5 мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан.

ЗДТГ:

- ЗДТГ-ын дарга Ш.Өнөрбаярт өндөр насны тэтгэвэр тогтоолгож ажлаас чөлөөлөгдсөн төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо үндсэн цалингийн дунджийг 36 сараар бус 42 сараар тооцоолж 3,782.6 мянган төгрөг илүү олгосон,

ЕБС:

- Орхонтуул сумын 1 дүгээр сургуулийн захирал Д.Долгормаад 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.
- Рашаант тосгоны 2 дугаар сургуулийн захирал Н.Бүрэнцогтод 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.

Цэцэрлэг :

- Эрхлэгч З.Энхцолмонд 964.9 мянган төгрөгийн урамшууллыг улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЗДН хөрөнгийн зарцуулалт нь тус сумын нутаг дэвсгэрт буусан байгалийн онц аюултай үзэгдэл болох усны үерийн улмаас үүсэн хор хохирлыг арилгах, малын халдварт шүлхий өвчин дэгдэлтийг зогсоох зэрэг зардалд зарцуулагдсан байна.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөвт батлах тухай” 10 дугаар тогтоолоор татварын орлогын 72,207.0 мянган төгрөгөөр татварын бус орлогыг 13,600.0 мянган төгрөгөөр, нийт орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 85,807.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 213,433.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 127,626.3 мянган төгрөгөөр буюу 2.5 дахин биелүүлсэн байна.

Хүснэгт №7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	/мянган төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хувь хүний орлогын албан татвар	20,000.0	29,264.5	9,264.5	146.3
Хөрөнгийн албан татвар	6,100.0	27,228.3	21,128.3	446.4
Хөрөнгө борлуулсны орлого	2,000.0	10,474.0	8,474.0	523.7
Бууны албан татвар	1,770.0	1,676.0	(94.0)	94.7
Малд ногдуулах албан татвар	-	96,086.2	96,086.2	-
Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	3,000.0	1,391.1	(1,608.9)	46.4
Түгээмэл тархацтай байгалийн нөөц ашигласны төлбөр	754.0	215.0	(539.0)	28.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,500.0	3,468.0	(1,032.0)	77.1
Газрын төлбөр	22,083.0	5,053.7	(17,029.3)	22.9
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	12,000.0	24,969.5	12,969.5	208.1
Хүү торгуулийн орлого	13,100.0	13,606.9	506.9	103.9
Нийт дүн	85,307.0	213,433.2	128,126.2	250.2

Төсвийн орлогын төлөвлөгөө 2.5 дахин биелэхэд малд ногдуулах албан татвар 96,086.2 мянган төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 21,128,3 мянган төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 12,969.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Хувь хүний орлогын албан татвар:** Тайлант жилд малчдад олгосон ноос, ноолуурын урамшууллаас суутгасан орлогын албан татвараас шалтгаалан орлого 9,254.5 мянган төгрөгөөр,
- **Малын татвар:** Малын тоо толгойн албан татварын хууль хэрэгжсэнээр төлөвлөгөөнд тусгагдаагүй 96,086.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн.
- **Хөрөнгийн албан татвар:** Банкны хадгаламжийн хүүгийн орлогыг аймгийн төсөвт бус тухайн сумын орон нутгийн орлогот төвлөрүүлсэнтэй холбоотойгоор 21,128.3 мянган төгрөгөөр,

- **Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого:** Худалдан борлуулсан үл хөдлөх хөрөнгийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор орлого 8,474.0 мянган төгрөгөөр,
- **Байгалийн ургамал ашигласны татвар:** Хадлангийн талбайн хэмжээг нэмэгдүүлэн олгосноор ургамал ашигласны татварын орлого 12,969.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Газрын төлбөр:** Газрын төлбөрийн орлого 17,029.3 мянган төгрөгөөр тасарсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 3,695,363.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 85,807.0 мянган төгрөг, эхний үлдэгдлээс санхүүжих 212,320.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,062,542.8 мянган төгрөг, ОНХС-аас олгох шилжүүлгийг 238,362.0 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 1,872,857.2 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 20,000.0 мянган төгрөг, ЭМДС-аас 38,382.0 мянган төгрөг, өөрийн орлогын 500.0 мянган төгрөг зэрэг нийт 3,530,271.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор ОНХС-ийн зарцуулалтыг урьд оны санхүүжилтийн үлдэгдлээс 28,396.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, ОНХС-ийн зарцуулалтыг нийт **400,551.1** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн 2021 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан аймгийн Засаг даргаас хүргүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 23-ны 01/768 дугаар “2021 оны тодотгосон төсөв хүргүүлэх тухай” албан бичгийг үндэслэн тусгай шилжүүлгийн байгууллагын төсөвт өөрчлөлт оруулан тодотгол хийсэн байна.

Сумын ИТХ нь “Орхонтуул сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 11 дүгээр сарын 28-ны 25 дугаар тогтоолоор татварын орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулалгүйгээр буюу нийт орлогыг 85,807.0 мянган төгрөгөөр, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,072,542.8 мянган төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг 82,021.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,954,878.3 мянган төгрөгөөр, ОНХС-ийн санхүүжилтийг 400,551.1 мянган төгрөгөөр, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 98,527.0 мянган төгрөгөөр, ЭМДС-ийн орлогыг 38,382.2 мянган төгрөгөөр зэрэг нийт орлого, зарлагыг тус бүр 3,650,688.4 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Үүнээс ТЗШ-ийн байгууллагуудад 1,993,260.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс ТЗШ-ийн байгууллагуудад 390,463.3 мянган төгрөг, ИТХ-д 55,079.4 мянган төгрөг, ЗДТГ-д 389,479.6 мянган төгрөг, Захирагчийн албанд 134,437.9 мянган төгрөг, соёлын төвүүдэд 188,889.6 мянган төгрөг, ОНХС-д 400,551.1 мянган төгрөг,

СХС-ийн зээлд 98,527.0 мянган төгрөгийн зэрэг нийт 3,650,688.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна.

Аймгийн БСГ-аас 12 дугаар сард хийсэн төсвийн зохицуулалтаар ТШЗ-д олгох санхүүгийн дэмжлэгийг 15,000.0 мянган төгрөгөөр бууруулсан тул нийт санхүүжилт **3,635,688.4** мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 16 хөтөлбөрт зориулан нийт **3,339,624.5** мянган төгрөг, үүнээс 2,994,380.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 270,243.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 75,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр ТЗШ-ийн байгууллагуудын санхүүжилт 1,888,212.5 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 1,072,542.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс **213,433.2** мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 240,716.1 мянган төгрөг, ОНХС-аас 238,362.0 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 74,565.9 мянган төгрөг, ЭМ-ийн даатгалын сангаас 27,928.6 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 465.1 мянган төгрөг зэрэг нийт **3,756,226.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,339,624.5 мянган төгрөг буюу 91.9 хувьтай тайлагнагдсан нь ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн болон харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлтээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нийт 66,166.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 34,928.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 256.6 мянган төгрөгөөр, нормативд зардал 16,398.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,506.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал 18,753.4 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардал 4,679.4 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 130,853.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж, сум хөгжүүлэх сангийн 22,342.2 мянган төгрөгийн зээл олгогдоогүй байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 24 төсөл, арга хэмжээнд 400,551.1 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, 16 төсөл арга хэмжээнд 270,294.9 мянган төгрөг зарцуулж, 8 төсөл арга хэмжээний 130,307.1 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 88,637.4 мянган төгрөг, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан 15,000.0 мянган төгрөг, хандив 36,306.0 мянган